

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2019 оны 06 дугаар
Сарын 21-ний өдөр

Дугаар АГТ-19/116109/38 Улаанбаатар хот

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн барилга угсралтын болон ашиглалтын үйл ажиллагааны байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ, байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулах, батлуулах ажлыг хийх гэрээг (цаашид "Гэрээ" гэх)

Нэг талаас: "Монголын төмөр зам" ТӨХК (цаашид "Захиалагч" гэх),

Нөгөө талаас: "Өндөрхаан трейд" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх), (цаашид хамтад нь "Талууд" гэх) нар гэрээнд заасан нөхцлөөр ажил гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулах үүднээс харилцан тохиролцож байгуулав.

1.2. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын 414,6 километрийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ, байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулах, батлуулах ажил /цаашид ажил гэх/-ыг гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгөх, Захиалагч нь тохиролцсон ажлын хөлсийг төлөхтэй холбоотой үүсэх харилцаанд талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж зохицуулна.

1.3. Энэхүү гэрээ нь энэ гэрээ болон түүний хавсралтуудаас бүрднэ. Гэрээ, түүний хавсралтад оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

2. Гэрээний зүйл

2.1. Гэрээний зүйл нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийж, эрх бүхий байгууллагаар баталгаажуулах, энэхүү гэрээнд заасны дагуу гүйцэтгэх цогц ажил байна.

3. Баталгаа

3.1. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу ажил гүйцэтгэх, гэрээнээс үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, энэхүү гэрээг байгуулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, эрхийг эрх бүхий байгууллагаас авсан, тэдгээр нь гэрээний үүргийг зохих ёсоор бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр, гэрээнд заагдсан ажлыг гүйцэтгэх боловсон хүчний болон санхүүгийн бүрэн чадамжтай гэдгийг үүгээр баталж байна.

3.2. Гүйцэтгэгч нь ажлыг хууль тогтоомж болон энэ гэрээнд заасан шаардлагад нийцүүлэн, эрхийн болон биет байдлын доголдолгүй, холбогдох бичиг баримт нь үнэн зөв, бүрэн гүйцэд хүлээлгэж өгнө гэдгийг үүгээр баталж байна.

3.3. Талууд энэхүү Гэрээг байгуулахтай холбогдуулан мэдсэн нөгөө талын үйл ажиллагаатай холбоотой нууц мэдээллийг тухайн талын зөвшөөрөлгүйгээр хууль болон энэ гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй, энэхүү гэрээнээс үүссэн харилцаанаас өөр бусад зорилгоор ашиглахгүй байхыг үүгээр баталж байна.

4. Хууль тогтоомж, гэрээг тайлбарлах

4.1. Талууд энэхүү гэрээг Монгол Улсын хууль тогтоомжид үндэслэн, эрх бүхий байгууллагаас баталсан аливаа дүрэм, журам, заавар, стандарт, шаардлагад нийцүүлэн талуудын хоорондын эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан байгуулав.

4.2. Гэрээний зүйл заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд хэрэв энэ гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хуульд

заасныг баримтална.

5. Гэрээг байгуулсанд тооцох

5.1. Гэрээнд талуудын төлөөлөх эрхтэй этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

5.2. Гэрээг монгол хэлээр хоёр хувь үйлдэх ба Гүйцэтгэгч нэг хувийг, Захиалагч нэг хувийг тус тус хадгалах бөгөөд хувиуд хууль зүйн адил хүчинтэй байна.

5.3. Талууд гэрээг бүртгүүлэх, батлуулах шаардлагатай тохиолдолд түүнтэй холбоотойгоор холбогдох бүхий л баримт бичиг, мэдээллийг гарган өгч хамтран ажиллана.

6. Гүйцэтгэх ажил, ажлын гүйцэтгэл

6.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь өгөгдсөн талбайд Захиалагчийн өгсөн ажлын даалгаврын дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийж, эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан ажлын үр дүнг захиалагчид хүлээлгэн өгнө.

6.2. Ажлыг энэхүү гэрээний хавсралтаар батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэнэ. Ажлыг гүйцэтгэхдээ гэрээний хавсратад заасан цар хүрээгээр хязгаарлагдахгүй бөгөөд хууль тогтоомж, дүрэм журамд заасан ажлыг зохих ёсоор бүрэн гүйцэтгэнэ.

6.3. Ажлын үр дүн болох судалгааны ажил, ажлын тайлан, эх материал, солбицлын жагсаалт, тоон мэдээлэл, түүхий дата болон түүнд хавсаргасан фото, схем зураг, диаграм болон бусад холбогдох дагалдах зүйлс нь захиалагчийн өмчид тооцогдоно.

6.4. Талууд ажлын гүйцэтгэлийн хувь хэмжээ, явц, чанарын талаар харилцан тохиролцож чадаагүй, эсхүл аль нэг талын гаргасан тайлбар, үндэслэл, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй, тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан бол захиалагчийн сонгосон шинжээчээр дүгнэлт гаргуулж, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулна. Ийнхүү дүгнэлт гаргуулахад гарсан нэмэлт зардлыг ажил гүйцэтгэгч бүрэн хариуцна.

7. Ажил гүйцэтгэх хугацаа

7.1. Ажил гүйцэтгэгч нь ажлыг 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн дотор гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж хүлээлгэн өгнө.

7.1.1. 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн дотор байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайланг гарган Захиалагчид ирүүлнэ.

7.1.2. 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс 07 дугаар сарын 21-ний өдрийн дотор Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулахаар Захиалагчийн холбогдох баримт бичгийн бүрдлийн хамт Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлэн, дүгнэлт гаргуулна.

7.1.3. 2019 оны 07 дүгээр сарын 21-ний өдрөөс Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтийн дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулж, 08 дугаар сарын 21-ний өдрийн дотор Байгаль орчин аялал жуулчлалын яамны мэргэжлийн зөвлөлийн хуралд танилцуулж, батлуулна.

7.2. Гүйцэтгэгч нь хийгдэж буй ажлаа Захиалагчийн шаардсан тухай бүрт Захиалагчид хүргүүлэн ажиллана.

7.3. Ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, ажил гүйцэтгэхэд шаардагдах техник тоног төхөөрөмжийг тээвэрлэхэд гарсан аливаа саатал, эрсдэл, санхүүгийн хүндрэл, энэ гэрээнд заасны дагуу ажлын гүйцэтгэлийн доголдлыг арилгасан зэрэг нь ажил гүйцэтгэх хугацааг зөрчөх буюу хойшлуулах үндэслэл болохгүй.

7.4. Ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл хугацаа хожимдуулж гүйцэтгэсэн нь ажил гүйцэтгэгчид захиалагчийн зүгээс энэ гэрээнд заасан алданги болон торгууль ногдуулах үндэслэл болно.

8. Ажлын доголдлыг арилгах, гомдлын шаардлага гаргах

8.1. Гүйцэтгэгч нь ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, эсхүл захиалагчийн болон төрийн эрх

бүхий хяналтын байгууллагын бичгээр өгсөн чиглэл, удирдамжийг зөрчиж гүйцэтгэсэн нь ажлын гүйцэтгэлийг хянах явцад болон энэ гэрээний гомдлын шаардлага гаргах хугацаанд илэрсэн бол уг зөрчлийг өөрийн хөрөнгөөр засаж доголдлыг арилгах, үүнээс үүсэн захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

8.2. Гүйцэтгэгч ажлын үр дүнгийн доголдлын талаар санаатай нуун дарагдуулсан нь хожим илэрвэл тэрээр хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан шууд болон шууд бус хохирлыг бүрэн хариуцна.

8.3. Гүйцэтгэгч гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол байвал захиалагч энэ тухай гомдлын шаардлагыг ажил хүлээн авснаас хойш гурван жилийн дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

9. Мэдээлэл солилцох, мэдээллээр хангах

9.1. Талуудын албан ёсны хаяг:

9.1.1. Захиалагч: "Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компани

Улсын бүртгэлийн дугаар: 9012001025

Регистрийн дугаар: 5214203

Хаяг: Юнион бюлдинг, А блок, 7 давхар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол, Нарны зам-62, Улаанбаатар /14230/

Утас: 7000-6622, 7010-6655

Имэйл: info@mtz.mn

9.1.2. Гүйцэтгэгч: "Өндөрхаан трейд" ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011016112

Регистрийн дугаар: 2640686

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: 122

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Санкт-Петербург төв 217 тоот.

Утас: 7000-2578, 9999-8547, 88112518

Имэйл: info@undurkhaan.mn

9.2. Гэрээний талууд үйл ажиллагаа эрхлэн явуулахад шаардлагатай мэдээллийг харилцан солилцож байна.

9.3. Мэдээллийг бичгээр болон факс, и-мэйл зэрэг цахим хэлбэрээр солилцоно.

9.4. Хойшлуулшгүй тохиолдолд талууд мэдээллээ амаар болон утсаар солилцож болох боловч ийнхүү солилцсон мэдээллээ баталгаажуулж 48 цагийн дотор нөгөө талд хүргүүлнэ.

9.5. Мэдээлэл солилцооноос үүсэх хохирлыг захиалагч хариуцахгүй.

9.6. Захиалагч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ баримт, судалгаа, зааварчилгааг ажил гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу боломжит хугацаанд гаргаж өгнө.

10. Ажил хүлээлцэх

10.1. Талууд ажлын гүйцэтгэлийг хүлээлцэхдээ тал тус бүрээс 2-оос доошгүй ажилтан оролцуулсан ажил хүлээлцэх комисс байгуулж ажлыг хүлээлцэнэ.

10.2. Талууд гэрээний дагуу ажлын гүйцэтгэлийг хүлээлцсэнээс хойш 5 /тав/ хоногийн дотор ажлын бичиг баримтыг акт үйлдэн хүлээлцэнэ.

10.3. Бичиг баримтыг хүлээлцэхдээ бичиг баримтын бүрдэл бүрэн гүйцэт, үнэн зөв эсэхийг шалган, Захиалагч бичиг баримтын эх хувийг хүлээн авна. Гүйцэтгэгч бичиг баримтын бүрдэл бүрэн гүйцэт, үнэн зөв эсэхийг хариуцан хүлээлгэн өгнө.

10.4. Байгаль орчны үнэлгээний тухай хуульд зааснаар байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг есөн хувь үйлдэн захиалагч болон холбогдох газруудад хүргүүлнэ.

10.5. Гүйцэтгэгч өөрийн архивт авч үлдсэн хувиас шаардлагатай тохиолдолд захиалагчийн хүсэлтийн дагуу үнэ төлбөргүй хуулбарлан авах боломжоор хангаж хуулбарыг баталгаажуулна.

10.6. Ажил хүлээлцэж дууссаны дараа захиалагч Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр

замын төслийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байгал орчны нарийвчилсан үнэлгээний эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан тайлантай болсон байна.

10.7. Ажлын гүйцэтгэлийн үр дүн нь Захиалагчийн өмч байна.

11. Ажлын хөлс

11.1. Энэхүү гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх ажлын хөлс нь нийт 129,965,000 /нэг зуун хорин есөн сая есөн зуун жаран таван мянга/ төгрөг /цаашид "гэрээний үнэ" гэх/ байна.

11.2. Ажлын хөлсөнд холбогдох НӨАТ болон холбогдох бүх төрлийн татвар, хураамж үндсэн ажлын зардал болон хяналтын зардал, тайланг эрх бүхий байгууллагаар батлуулах зардал, бусад холбогдох зардлууд багтсан болно.

11.3. Ажил гүйцэтгэх хугацаанд ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн бараа, материал, түлшний үнэ өссөн, Засгийн газраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэн тогтоосон болон Захиалагчаас үл шалтгаалах байдлаар ажлын өртөг нэмэгдэхтэй холбогдсон эрсдэлийг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

12. Төлбөр тооцоо

12.1. Энэхүү гэрээний дагуу төлөх ажлын хөлсний 30 хувьтай тэнцэх хэсгийн 38,989,500 /гучин найман сая есөн зуун наян есөн мянга таван зуу/ төгрөгийг гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулан, урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлснээс хойш ажлын 10 өдөрт багтаан төлнө.

12.2. Ажлын хөлсний 30 хувьтай тэнцэх хэсгийн 38,989,500 /гучин найман сая есөн зуун наян есөн мянга таван зуу/ төгрөгийг байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлнө.

12.3. Ажлын хөлсний 35 хувьтай тэнцэх хэсгийн 45,487,750 /дөчин таван сая дөрвөн зуун наян долоон мянга долоон зуун тавь/ төгрөгийг төрийн эрх бүхий байгууллага болон Захиалагчийн томилсон эрх бүхий этгээд ажлыг чанартай гүйцэтгэсэнд тооцож акт үйлдэн хүлээн авсанаас хойш ажлын 10 хоногт багтаан гүйцэтгэлээр нь төлнө.

12.4. Захиалагч тал төлбөрийг гүйцэтгэгч компанийн *Меридиан* банк *340,000,334.04* тоот дансанд шилжүүлсэн өдрийг ажлын хөлсийг төлсөн өдөрт тооцно.

12.5. Гэрээний үнийн 5 /арав/ хувийг Гүйцэтгэгч нь ажлын чанарын баталгаа болгон үлдээх ба Захиалагчид хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 6 сар хугацаанд Захиалагчийн дансанд барьцаанд үлдээнэ.

13. Захиалагчийн эрх, үүрэг

13.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах;

13.2. Ажлын явцын тайланг Гүйцэтгэгчээс авах;

13.3. Гүйцэтгэгч талын гүйцэтгэж буй судалгааны ажил, бусад дагалдах ажилд хяналт тавьж, цаг тухайд нь шалгах, шаардлага тавих;

13.4. Гүйцэтгэгч талын үйл ажиллагааны алдаа, зөрчлүүдийн улмаас үүсэн гарсан аливаа хохирлыг нөхөн төлүүлэх, судалгааны ажлын тайлан, дүгнэлтийн хувьд гарсан бүх алдаа, зөрчлийг үнэ төлбөргүй дахин боловсруулуулах, шинэчлүүлэх талаар шаардлага тавих;

13.5. Шаардлагатай тохиолдолд ажлын гүйцэтгэлд нарийн мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх эрхтэй.

13.6. Захиалагч нь энэхүү гэрээнд заасны дагуу гэрээний төлбөрийг Гүйцэтгэгчид хугацаанд нь төлөх;

13.7. Гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгэхэд өөрсдийн зүгээс шаардлагатай туслалцааг Гүйцэтгэгч талд үзүүлэх;

13.8. Захиалагчийн зүгээс ажил хийж гүйцэтгэхтэй холбогдсон шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;

13.9. Энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ,

14. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 14.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Захиалагчаас шаардах;
- 14.2. Гэрээнд заасны дагуу гэрээний төлбөрийг хүлээн авах;
- 14.3. Захиалагч талаас гаргаж өгөх ажлын хүрээндэх мэдээ материалыг боломжит цаг хугацаанд нь шаардан авах;
- 14.4. Гэрээнд заасан ажлыг Захиалагчаас өгсөн Техникийн даалгаврын дагуу, сүүлийн үеийн баталгаажсан техник, технологийг ашиглан гүйцэтгэн, хүлээлгэн өгөх;
- 14.5. Ажлын үр дүн, тайлан дүгнэлтийг Захиалагчаар хянуулан, баталгаажуулах;
- 14.6. Ажлын үр дүн, тайлан дүгнэлтэд тусгагдсан норматив болон тооцооны үзүүлэлтүүдийн үнэн зөвийг бүрэн хариуцах;
- 14.7. Гэрээт ажил, тайлан дүгнэлттэй холбогдсон алдаа, зөрчил, Техникийн даалгаврын дагуу гүйцэтгэгдээгүй ажил бий болсон тохиолдолд Захиалагчид дахин үнэ төлбөргүйгээр засч өгөх, хохирлыг барагдуулах;
- 14.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг хариуцах үүрэгтэй.
- 14.9. Энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

15. Нууцлал

- 15.1. Гэрээ нь Талуудын нууцад хамаарах бөгөөд хууль болон гэрээнд зааснаас бусад тохиолдолд нөгөө Талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээний талаархи аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.
- 15.2. Хуульд заасны дагуу байгууллагын нууцтай танилцах эрх бүхий төрийн байгууллага, түүний албан хаагч энэ зүйлд заасан мэдээлэлтэй танилцахаар хүсэлт гаргасан, эсхүл шаардсан тохиолдолд талууд уг мэдээллийг хуульд заасан журмын дагуу танилцуулах бөгөөд энэ талаар нөгөө талдаа заавал урьдчилан мэдэгдэнэ.
- 15.3. Талуудын аль нэг нь энэ зүйлд заасан үүргээ зөрчсөний улмаас нөгөө талын бизнесийн нэр хүндэд ноцтой хохирол учирсан, материаллаг хохирол учруулсан бол буруутай тал нь түүнийг бүрэн хариуцна.

16. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

- 16.1. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 16.2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нөгөө Талдаа саналаа бичгээр хүргүүлэх бөгөөд тухайн саналд нэмэлт, өөрчлөлтийн үндэслэл, түүний төслийг тусгана.
- 16.3. Саналыг хүлээн авсан тал ажлын 7 хоногийн дотор хариу ирүүлэх үүрэгтэй бөгөөд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.
- 16.4. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

17. Гэрээний зөрчлийг арилгах, гэрээ цуцлах

- 17.1. Талууд гэрээний үүргийн зөрчлийг арилгах тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мэдэгдлийг хүлээн авсан тал гэрээний зөрчлийг 10 хоногийн дотор арилгаж хариу мэдэгдэх үүрэг хүлээнэ.
- 17.2. Хэрэв зөрчил гаргагч Тал зөрчлийг 10 хоногийн дотор арилгах боломжгүй бол энэ тухай нөгөө Талдаа мэдэгдэх бөгөөд зөрчил арилгах хугацааг Талууд харилцан тохиролцож тогтооно.
- 17.3. Талууд гэрээг цуцлах саналтай байгаа бол уг саналаа нөгөө Талд бичгээр хүргүүлж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 17.4. Захиалагч нь дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:
 - 17.4.1. Гүйцэтгэгч энэ гэрээний дагуу ажил гүйцэтгэх хуваарь болон хугацааг 5 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн;
 - 17.4.2. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэхдээ чанарын ноцтой доголдол гаргасан бөгөөд захиалагч ажлыг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй гэж үзсэн;
 - 17.4.3. Гүйцэтгэгч нь ажлын доголдлыг боломжит хугацаанд арилгаагүй, эсхүл ийнхүү арилгахаас зайлсхийсэн;
 - 17.4.4. Гүйцэтгэгчийн баталгаа нь хуурамч болох нь илэрсэн;

- 17.4.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.
- 17.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:
- 17.5.1. Захиалагч төлбөрөө шилжүүлэх хугацааг 20 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн, цаашид боломжит хугацаанд шилжүүлэхгүй нь тодорхой болсон;
- 17.5.2. Захиалагч ажлын хамрах хүрээг өөрчилсөн нь энэхүү гэрээнд заасан ажлын хөлсийг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг бий болгосон бөгөөд захиалагч нэмэлт санхүүжилтийг гаргахаас үндэслэлгүйгээр татгалзсан;
- 17.5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.
- 17.6. Гэрээг цуцалсан тохиолдолд ийнхүү цуцалснаас хойш ажлын 3 хоногийн дотор гэрээ цуцалсан өдрөөр тасалбар болгон Захиалагч гуравдагч ажил гүйцэтгэгчээр ажлыг гүйцэтгүүлэх эрхтэй. Хэрэв гүйцэтгэгчийн зохих ёсоор гүйцэтгээгүй ажлыг гуравдагч ажил гүйцэтгэгч үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжтой тохиолдолд тухайн ажилд ногдох гүйцэтгэгчийн зардлыг захиалагч төлөх тохиолдолд гуравдагч ажил гүйцэтгэгчтэй зөвшилцсөнийг үндэслэн тооцно.
- 17.7. Гэрээнд заасны дагуу аль нэг Талын санаачилгаар Гэрээг цуцалсан бол буруутай Тал ийнхүү цуцалсантай холбоотой зардал болон нөгөө Талд учирсан хохирлыг нөхөн төлнө.


18. Хариуцлага

- 18.1. Гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.
- 18.2. Энэ гэрээний 18.4-д заасны дагуу гэрээг захиалагчийн санаачлагаар цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний торгууль хүлээх бөгөөд захиалагчид учирсан хохирлыг бүрэн хариуцна.
- 18.3. Захиалагч нь энэ гэрээнд заасан үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги хүлээнэ.
- 18.4. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээнд заасны дагуу нэг талын санаачилгаар гэрээг цуцалсан бол буруутай тал нөгөө талд учруулсан аливаа хохирол болон зардлыг нөхөн төлнө.
- 18.5. Хэрэв аль нэг тал нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь шаардах эрхээ хэрэгжүүлээгүй бол энэ нь эрхээсээ татгалзсан гэж тооцохгүй бөгөөд эрхээ хожим хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авахад саад болохгүй.
- 18.6. Аль нэг тал Гэрээгээр хүлээсэн үүргээ давагдашгүй хүчин зүйлийн улмаас зохих ёсоор биелүүлээгүй болох нь нотлогдвол үүрэг давагдашгүй хүчин зүйлийг арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно. Захиалагч төрийн эрх бүхий байгууллагаас хамааралтайгаар гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд саад учирсан тохиолдолд Захиалагчийн үүрэг тухайн нөхцөлийг арилах хүртэл хугацаагаар хойшилно.

19. Маргаан шийдвэрлэх

- 19.1. Талууд харилцан хүндэтгэлтэй, бизнесийн ёс зүйг чанд сахиж, гэрээтэй холбоотой аливаа маргаан гарахаас урьдчилан сэргийлж ажиллана.
- 19.2. Энэхүү гэрээг тайлбарлах болон түүний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэнэ.
- 19.3. Талууд харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

20. ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



Б.ЦЭНГЭЛ



Х.МААМАА

УЛААНБААТАР ХОТ
БАТЛАВ МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
ТӨХК-ИЙН ХИЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ТӨХК Б.ЦЭНГЭЛ

117144653

ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

1. Зорилго:

“Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн төмөр замын төслийн барилга угсралтын болон ашиглалтын үйл ажиллагааны байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ, БОННУ тайлан боловсруулах.

2. Хамрах хүрээ:

2.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд дараах объектуудыг хамруулана.

• Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилга угсралтын ажилтай шууд холбоотой болон барилга угсралтын явцад ашиглагдах түр болон байнгын барилга байгууламж, дэд бүтэц. Үүнд:

- Төмөр замын дэд бүтэц
- Цэвэрлэх байгууламж
- Эрчим хүчний шугам
- Шатахуун түгээх станц, агуулах
- Барилга, орон сууц
- Ажилчдын хотхонууд
- Технологийн зам
- Бетон зуурмагийн үйлдвэр
- Бусад барилга угсралтын талбай.

3. Хийгдэх ажлууд, үе шатууд:

3.1. Урьдчилсан судалгаа үнэлгээ:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ

3.2. Хээрийн судалгааны шат:

- Төсөл хэрэгжих орчны суурь нөхцөл байдал болон байгаль орчныг хамгаалах талаар авах арга хэмжээг тодорхойлох үүднээс ус, хөрс, агаар, ургамал, амьтан, түүх соёлын өвийн асуудлаар судалгаа хийх, дүгнэлт гаргах;

3.3. БОННУ дунд хугацааны тайлан:

- Төслийн техник, технологи, химийн болон биологийн бодис, түүхий эд, туслах материал, завсрын бүтээгдэхүүн, хог хаягдал, нийгмийн асуудлын талаар судалгаа хийх;
- Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийн хэмжээ, тархалт, үр дагаврыг тогтоосон тооцоо, судалгаа, түүнийг арилгах арга хэмжээний

техникийн шинжтэй, алдаагүй, шууд хуулбарлаагүй, үнэн бодит мэдээлэлд тулгуурласан судалгаанд үндэслэсэн байна.

- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын байгаль орчны нөлөөллийн үнэлгээг боловсруулж, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг БОМ төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгана.
- Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний шаардлага:
 - Дүйцүүлэн хамгаалалт хийгдэх газрын орчны суурь судалгааны тайлан боловсруулна
 - Биологийн олон янз байдлын судалгааг хийж, экологийн ач холбогдол бүхий зүйл, бүлгэмдэлийг тодорхойлно
 - Антропоген хүчин зүйлийн нөлөөлөлд автах эрсдэл бүхий зүйл, бүлгэмдлийг тодорхойлсны үндсэнд биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээний хувилбаруудыг тодорхойлно
 - БОЯБайдлын мониторинг хийх давтамж, хэлбэр, аргагүй тодорхойлно.
- Сөрөг нөлөөллийн үнэлгээ нь бодит тооцоонд тулгуурласан байна. Бохирдуулагчийн хэмжээг тооцохдоо уур амьсгалын онцлог, хөрсний шинж чанар, хэмжилт шинжилгээний мэдээний дүн, төмөр зам бүрэн хүчин чадлаараа ажиллах үеийн машин механизмын тоо, рейс, технологийн процесст үндэслэнэ.
- Завсрын бүтээгдэхүүн, хог хаягдлын жагсаалтыг гаргаж нэр төрөл, хэмжээ эх үүсвэр, устгах арга хэлбэрийн хувилбаруудыг оруулна.
- Хог хаягдлын менежментийн хүрээнд удирдлага зохион байгуулалтыг төлөвлөх, хог хаягдлыг зайлуулах байршил, дахин боловсруулах арга хэлбэр, хувилбаруудыг оруулна.
- Талбайгаас дээж авах тоо, байршлууд нь төслийн байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн байгаль орчны төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төслийг боловсруулахад шаардагдах суурь мэдээ баримт болон ашиглагдахуйц байна.
- Орчны төлөв байдлын суурь мэдээлэл нь олон жилийн мэдээ баримтаас гадна хамгийн сүүлийн үеийн мэдээ баримтыг агуулна.
- Сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээ тус бүрд хэрэгжүүлэх хувилбаруудыг дэлгэрүүлж дотоодын болон олон улсын практикт мөрдөгддөг шилдэг туршлагаудыг дурдана.
- Төсөл хэрэгжих орчинд амьдардаг хүн амын нийтийн санал бодлыг биечлэн уулзаж, уулзалт ярилцлага зохион байгуулах хэлбэрээр авна. Уулзалтууд дараах хурлуудаас бүрдэнэ.
 - БОННУ урьдчилсан уулзалт, үнэлгээнд санал авах
 - БОННУ тайлангийн төслийг танилцуулах

6. Холбогдох баримт бичиг

- Монгол улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачилсан заавар
- Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр тайланг боловсруулах журам